



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/16

Арвайхээр

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-10.1.5, 32 дугаар зүйлийн 32.1.5, 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ний өдрийн “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд шинээр баригдсан бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс, Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс, Барилга байгууламжийн гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ захирамжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Т.Ариунболд), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамж батлагдсантай холбогдуулан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн томилох тухай” аймгийн Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/130 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0031

Аймгийн Засаг даргын 2022 оны...
дугаар сарын ...-ны өдрийн...
дугаар захирамжийн хавсралт



**БАГА, ДУНД, ӨНДӨР ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ
АШИГЛАЛТАНД ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга:

Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа,
барилга, хот байгуулалтын газрын Барилга,
хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын
газрын төлөөлөл (2-оос ихгүй улсын байцаагч)

Аймгийн Онцгой байдлын газрын төлөөлөл
(2-оос ихгүй улсын байцаагч)

Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа,
барилга, хот байгуулалтын газрын төлөөлөл

Зураг төслийн байгууллагын төлөөлөл
(холбогдох зураг төсөл зохиогчид)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг
хамгаалах байгууллагын төлөөлөл

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Инженерийн хангамжийн байгууллагын
төлөөлөл (тус бүр 1-ээс ихгүй)

Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх
зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга

Захиалагч байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа,
барилга, хот байгуулалтын газрын Барилга,
хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Тайлбар (Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно).

2.

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАДНА ТАЛБАЙН ТОХИЖИЛТ,
ЗАСВАРЛАХ, ТОНОГЛОХ АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**



Комиссын дарга: Захиалагч байгууллагын төлөөлөл

Гишүүд: Зураг төслийн байгууллагын төлөөлөл

Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

**ОНЦГОЙ ТӨВӨГШИЛТЭЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
АЖЛЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН**



1.Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасан барилга байгууламж болон аймгийн Засаг даргын хүсэлтээр Барилгын тухай хуулийн 10.1.5-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга: Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын асуудал хариуцсан нэгжийн дарга

Гишүүд: Зураг төслийн байгууллагын төлөөлөл
(холбогдох зураг төсөл зохиогчид)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Архивын байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Техникийн комиссын дарга

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

2.Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга: Төрийн захиргааны төв байгууллагын асуудал хариуцсан нэгжийн дарга

Гишүүд: Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төв байгууллагын төлөөлөл (2-оос ихгүй улсын байцаагч)

Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл (Барилгын тухай хуулийн 34.1.6, 34.1.7-д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагын төлөөлөл)

Онцгой байдлын асуудал хариуцсан төв байгууллагын төлөөлөл (2-оос ихгүй улсын байцаагч)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл
(холбогдох зураг төсөл зохиогчид)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл
(тус бүр 1- ээс ихгүй)

Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл;

Архивын байгууллагын төлөөлөл

4.

Нарийн бичгийн дарга: Захиалагч байгууллагын төлөөлөл

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

3.Аймгийн Засаг даргын хүсэлтээр Барилгын тухай хуулийн 10.1.5-д заасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга: Барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын төлөөлөл (Барилгын тухай хуулийн 34.1.6, 34.1.7-д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагын төлөөлөл)

Гишүүд: Мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөлөл (2-оос ихгүй улсын байцаагч)

Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл (2-оос дээшгүй улсын байцаагч)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл (холбогдох зураг төсөл зохиогчид)

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл (барилга байгууламжийн хувьд)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл

Инженерийн хангамжийн байгууллагын төлөөлөл (тус бүр 1-ээс ихгүй)

Ашиглалт хариуцах байгууллагын төлөөлөл

Архивын байгууллагын төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Захиалагч байгууллагын төлөөлөл

Тайлбар: Төлөөллийн тоо заагаагүй бол нэг гэж ойлгоно.

-oOo-

